Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ НАНЗАДЫН НАНДИНЦЭЦЭГ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН БИЕЛЭЛТ

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Салбарын хяналт шалгалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1.ТХШТХ-ийн 9.2.1 Хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлийн 10.6.1, 10.6.2, 10.6.4 кодтой хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж батлуулна. | Батлагдсан хяналтын хуудас | ЭМС-ын 2024 оны А/76 дугаар тушаал | Батлагдсан хяналтын хуудас-3 | 10.6.1, 10.6.2, 10.6.4 кодтой хяналтын хуудсанд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулан, удирдлагаар хянуулан Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/26 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан. | 2025.01.01-2025.02.28 | 100 |
| **Зорилт 2. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 2 | **Арга хэмжээ 2.1. Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоол, ЭМС-ын 2024 оны А/496 дугаар тушаал** Хүүхэд, өсвөр үеийн чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн | Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга | Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга | - | Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/496 дугаар тушаалын хавсралт дахь Эрүүл мэндийн салбарын 2025 оны төлөвлөгөөт хяналт шалгалтын объектын жагсаалтад хүүхэд өсвөр үеийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр аймаг, нийслэлийн нийт 316 | 2025.01-2025.06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсролын сургалтын байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт зохион байгуулна.<br>(ЭМЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 18) | | | | объектыг нэгтгэн боловсруулж, батлуулсан.<br>Тайлант хугацаанд хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуй, халдвар хамгааллын чиглэлээр 253 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, 80.1 хувийн гүйцэтгэлтэй, шалгалтад хамрагдсан объектуудыг эрсдэлийн түвшингээр үнэлэхэд 41 нь их эрсдэлтэй, 115 нь дунд эрсдэлтэй, 97 нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн байна. | | |
| | | Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэр | Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэр-1 | - | Увс аймагт хийгдсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын нэгдсэн дүн танилцуулгыг Удирдлагын зөвлөлийн хурлаар оруулж, шийдвэрлүүлсэн. | | |
| | Дэд арга хэмжээ 2.1.1.<br>Төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамж боловсруулж батлуулна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 10% | “Төлөвлөгөөт шалгалт хийх тухай” 03-00/02 дугаартай удирдамж боловсруулж, батлуулсан. | 2025.02.10 | 10 100 |
| | Дэд арга хэмжээ 2.1.2.<br>Увс, Өвөрхангай аймгийн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн боловсролын сургалтын байгууллагын 12 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг гүйцэтгэнэ. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 40% | Өвөрхангай аймагт Боловсролын сургалтын байгууллагын 6 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн. Шалгалтад хамрагдсан 3 цэцэрлэг “Бага” эрсдэлтэй, Хархорин сумын ерөнхий болосролын 1-р сургууль “Бага” эрсдэлтэй, Хужирт сумын ерөнхий болосролын 2-р сургууль “Дунд” эрсдэлтэй, Арвайхээр сумын ерөнхий болосролын 4-р сургууль “Дунд” эрсдэлтэй тус тус үнэлэгдсэн болно. Шалгалтаар илэрсэн зөрлийг | 2025.04-2025.05 | 40 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | арилгуулахаар 57 заалт бүхий 10-00-02/005/53, 10-00-02/005/54, 10-00-02/005/55, 10-00-02/005/56, 10-00-02/005/57, 10-00-02/005/58 дугаартай 6 албан шаардлага үйлдэж, холбогдох газруудад хүргүүлсэн.<br>Увс аймгийн 3 цэцэрэлэг, ерөнхий боловсролын 2 сургууль, политехникийн 1 коллеж нийт 6 боловсролын сургалтын байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийлээ. Шалгалтад хамрагдсан 6 объектын 5 нь бага эрсдэлтэй, 1 нь дунд эрсдэлтэй үнэлэгдсэн. Шалгалтын явцад 3 цэцэрлэгийн гал тогооноос 6 хоолны дээж, 4 байгууллагын ундны усны 4 дээж, нэг цэцэрлэгээс 1 хөрсний дээж, 54ш арчдас шинжилгээ авч, Увс аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. Шалгалтаар илэрсэн зөрлийг арилгуулахаар 51 заалт бүхий 10-00-02/005/24, 10-00-02/005/25, 10-00-02/005/26, 10-00-02/005/27, 10-00-02/005/28, 10-00-02/005/29 дугаартай 6 албан шаардлага үйлдэж, холбогдох газруудад хүргүүлж, гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаж байна. | | |
| | Дэд арга хэмжээ 2.1.3. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын Хяналт | Үндсэн арга хэмжээний | - | | Увс, Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газрын дарга, Боловсрол соёлын газрын Боловсролын | 2025.09-2025.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шалгалтын нэгжээс ирүүлсэн хяналт шалгалтын дүнг нэгтгэж, дүгнэлт цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт газрын удирдлагад танилцуулна. | гүйцэтгэлд эзлэх хувь | | | хяналтын улсын байцаагч, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн удирдлагыг байлцуулан аймгийн Засаг дарга, бусад холбогдох газрын дарга нарт урьдчилсан байдлаар шалгалтын нэгдсэн дүнг танилцуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хууль тогтоомж, стандартын шаардлага хангуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.<br>Төлөвлөгөөт хяналт шалгалт үргэлжилж байна. | | 40<br>100. |
| 3 | **Арга хэмжээ 2.2.**<br>Бүх шатны боловсролын сургалтын байгууллагуудын 2025-2026 оны хичээлийн жилийн бэлтгэл ажилд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулна. | Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга | 2024 оны хяналт шалгалтын танилцуулга | | Хяналт шалгалт хийх хугацаа болоогүй. | 2025.08-2025.11 | - |
| | Дэд арга хэмжээ 2.2.1.<br>Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамж боловсруулж батлуулна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 10% | хугацаа болоогүй | 2025.07-2025.08 | - |
| | Дэд арга хэмжээ 2.2.2.<br>Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын хяналт шалгалтын нэгжээс ирүүлсэн хяналт шалгалтын дүнг нэгтгэж, удирдлагад танилцуулж, шалгалтын нэгдсэн дүн мэдээг Боловсрол шинжлэх ухааны яамны | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | | хугацаа болоогүй | 2025.10-2025.11 | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Салбарын хяналтын газарт хүргүүлнэ. | | | | | | | |
| 4 | **Арга хэмжээ 2.3.** Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулна. | Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга | 2024 оны хяналт шалгалтын танилцуулга | | НХХААГ, ХБХСГ-тай хамтран хүүхдийн зуслангийн бэлтгэл ажилд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж байна. | 2025.05-2025.08 | - | 75% 45 оноо. |
| | Дэд арга хэмжээ 2.3.1. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамж боловсруулж батлуулна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 10% | “Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 10-00/15 дугаартай удирдамж боловсруулж, батлуулсан. | 2025.02.07 | 10 | 100 |
| | Дэд арга хэмжээ 2.3.2. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын хяналт шалгалтын нэгжээс ирүүлсэн хяналт шалгалтын дүнг нэгтгэж, удирдлагад танилцуулж, шалгалтын нэгдсэн дүн мэдээг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлнэ. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 20% | Тайлангийн хугацаанд Нийслэлийн ногоон бүсийн хүүхдийн зуслангийн бэлтгэл ажилд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг БЗД, СБД, СХД-ийн нийт гэсэн 6 зусланг хамруулан шалгалт хийгдсэн. Шалгалтын явцад унд ахуйн хэрэгцээний уснаас 5 дээж авч шинжлүүлэхээр лабораторид хүргүүлсэн. НЭМГ, НХХААГ, ХБХСГ-ын хамтарсан “Хүүхдийн зуслангийн бэлтгэл ажил, эрүүл ахуйн нөхцөл, хүнсний чанар, аюулгүй байдлыг хангуулах, анхаарах асуудал, халдварт өвчнөөс сэргийлэх, мөн Хүүхдийн зуслангийн гадна орчинд тавигдах ерөнхий шаардлага UCS 1204B:2025 стандартыг танилцуулах” сэдэвт сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Монголын Үндэсний Зуслангуудын холбоо, хүүхдийн зуслангуудын удирдлага, эмч нарын дунд зохион | 2025.07-2025.08 | - | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулсан. Шалгалт 50 хувьтай үргэлжилж байна. | | |
| **Зорилт 3. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 5. | **Арга хэмжээ 3.1.** Эрүүл ахуйн тухай хуулийн 5.3 Сургалтын боловсролын байгууллагын барилга байгууламжийн зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг нь өөрчлөхөд эрүүл ахуйн дүгнэлт гаргана. | Хүсэлтийн шийдвэрлэлт | 100% | 100% | Тайлангийн хугацаанд 4 байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу барилгын зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийж, шаардлага хангасан 4 байгууллагат улсын ахлах байцаагчийн дүгнэлтээр хариуг цаг тухайд нь өгч шийдвэрлэсэн. | 2025.01-2025.05 | 100 |
| | | Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга | | | Эрүүл мэндийн салбарын хяналтын газрын даргын баталсан Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, зураг төсөл зохиох, ашиглалтад оруулахад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 2025 оны 10-00/01 дугаартай удирдамжийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтээр сургалтын боловсролын байгууллагын барилга байгууламжийн зураг төсөл хянах чиглэлээр тайлант хугацаанд улсын хэмжээнд нийт 52 хүсэлтийн дагуу эрүүл ахуйн хяналт хийж гүйцэтгэсэн.<br>Нийт 52 байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу боловсролын сургалтын байгууллагын барилгын зураг төслийг хянаж, шаардлага хангаагүй | 2025.01-2025.05 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 7 байгууллагат албан бичгээр, шаардлага хангасан 45 байгууллагат улсын (ахлах) байцаагчийн дүгнэлтээр хариуг цаг тухайд нь өгч шийдвэрлэсэн байна. | | |
| 6. | **Арга хэмжээ 3.2.** Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалт Нялх, балчир, бага насны болон цэцэрлэгийн хүүхэд, ЕБС-ийн бага ангийн сурагчдад зориулсан хоол үйлдвэрлэл шинээр эрхлэхэд урьдчилан хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргана. | Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга | 2024 оны хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга | | Нялх, балчир, бага насны болон цэцэрлэгийн хүүхэд, ЕБС-ийн бага ангийн сурагчдад зориулсан хоол үйлдвэрлэлийг шинээр эрхлэхэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 2025 оны 10-00/14 дугаар бүхий удирдамжийг боловсруулж, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт цахимаар хүргүүлсэн. Хяналт шалгалтыг нийт 24 сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн газруудад хийж гүйцэтгэсэн байна. Хяналт шалгалтын явцад 10.12.1 кодтой “Хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах” хяналтын хуудсаар үнэлэхэд 15 буюу 62.5 хувь нь бага эрсдэлтэй үнэлэгдэж, улсын (ахлах) байцаагчийн дүгнэлт үйлдсэн. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар 12 заалттай 2 албан үйлдэж, холбогдох газруудад нь хүргүүлэн хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтэнд хяналт тавьж ажилласан. | 2025.01-2025.11 | 80<br>48 оноо |
| | Дэд арга хэмжээ 3.2.1. Нялх, балчир, бага насны болон цэцэрлэгийн хүүхэд, ЕБС-ийн бага ангийн сурагчдад | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 10% | “Нялх, балчир, бага насны болон цэцэрлэгийн хүүхэд, ЕБС-ийн бага ангийн сурагчдад зориулсан хоол үйлдвэрлэлийг шинээр эрхлэхэд урьдчилан сэргийлэх хяналт | 2025.02.06 | 10 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зориулсан хоол үйлдвэрлэл шинээр эрхлэхэд хяналт шалгалт хийх удирдамж боловсруулж батлуулна. | | | | шалгалт хийх тухай" 10-00/14 дугаартай удирдамж боловсруулж, батлуулсан. | | |
| | Дэд арга хэмжээ 3.2.2. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын Хяналт шалгалтын нэгжээс ирүүлсэн хяналт шалгалтын дүнг нэгтгэж, дүгнэлт цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт газрын удирдлагад танилцуулна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | | Хяналт шалгалт хийх хугацаа дуусаагүй, хийгдэж байна. | 2025.10-2025.11 | - |
| 7. | **Арга хэмжээ 3.9**. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн $5^2$.1-д заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус шалгалт хийнэ. | Шийдвэрлэлтийн хувь | 100% | 100% | Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл гомдлын дагуу улсын хэмжээнд 338 объектод төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийгдэж, хугацаанд нь шийдвэрлэсэн. | 2025.01-2025.11 | 90 |
| | Дэд арга хэмжээ 3.9.1. Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх удирдамж боловсруулж батлуулна. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 10% Тухай бүр | Тухай бүр удирдамж боловсруулж, батлуулсан. | 2025.01-2025.06 | 10 |
| | Дэд арга хэмжээ 3.9.2. Хяналт шалгалтын дүнг нэгтгэж, удирдлагад танилцуулж, шалгалтын нэгдсэн дүн мэдээг | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | | Шалгалтын явцад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар улсын байцаагчийн 64 заалт бүхий 18 албан шаардлага үйлдэж, холбогдох газруудад нь хүргүүлэн хугацаатай үүрэг | | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | холбогдох газарт хүргүүлнэ. | | | | даалгавар өгч, биелэлтэнд хяналт тавьж ажилласан. Зөрчил гаргасан нийт 28 байгууллага, аж ахуйн нэгжид 30.5 сая төгрөгний торгууль шийтгэвэр ногдуулж, 67.2 хувийг нь барагдуулсан. | | |
| **Зорилт 4. Орон нутаг дахь улсын (ахлах) байцаагчдыг бодлого, удирдлага, мэргэжил арга зүй.** | | | | | | | |
| 8. | **Арга хэмжээ 4.1.** Сургалтын хэрэгцээний үнэлгээг үндэслэн Орон нутаг дахь улсын байцаагчдыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулна. | Сургалтын тайлан | 2024 онд сургалт зохион байгуулсан | - | "Салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нь" сэдэвт сургалтын Хүүхэд, өсвөр үеийн хяналтын чиглэлээр "2024 оны төлөвлөлт, анхаарах асуудал"-ын талаарх мэдээлэл бэлтгэж нэгтгэсэн. "Хүүхэд, өсвөр үеийн чиглэлээр 2025 онд хяналт шалгалт хийх төлөвлөлт" талаарх мэдээлэл бэлтгэж аймаг, нийслэлийн ЭМГ-ийн нийт албан хаагчдад сургалт зохион байгуулсан. | 2025.02 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Хувь хүний хөгжлийн сургалтад хамрагдана. | Сургалтын гэрчилгээ | - | - | "Монголын залуу эрдэмтдийн холбоо" ТББ-ын сургалтын төвийн "Хувь хүний хөгжил-эерэг хандлага" сэдэвт цахим сургалтад амжилттай суралцаж, гэрчилгээ авсан. | 2025.03.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Мэргэжлийн чиглэлээр сургалтад хамрагдсан байна. | Сургалтын гэрчилгээ | - | - | Хугацаа болоогүй | 2025.01-2025.11 | - |

ТАЙЛАН ГАРГАСАН:

УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ ........................................ /Н.НАНДИНЦЭЦЭГ/ 2025.06.10

*(Албан тушаал)* *(Нэр, гарын үсэг)* *(Огноо)*